



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 14 өдөр

Дугаар A/64

Мандалговь

Г “Бадамлянхуа дэлгэрэх” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 03 сарын 03-ны өдрийн А/87 тоот захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Гамшигийн эрсдлийг бууруулах нөөц” ажлын батлагдсан зардлаас 576 шуудай (14400 кг) тэжээл нийлүүлэх ажлыг “Бадамлянхуа дэлгэрэх” ХХК-тай 8,640,000 (найман сая зургаан зуун дөчин мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заасан хугацаанд 576 шуудай (14400 кг) тэжээл хүлээлгэж өгөхийг “Бадамлянхуа дэлгэрэх” ХХК-ны захирал (Н.Баярдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал) ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ / Л.Доржбат

486210288